ХОРИО ЦЭЭРИЙН ХЭЛТСИЙН ЭМ БИОБЭЛДМЭЛИЙН ХЯНАЛТ ХАРИУЦСАН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ М.ПҮРЭВСҮРЭНГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт арга хэмжээний биелэлт**

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхлэсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 2. Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах** | | | | | | | |
| 2 | Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | -2024 оны эхний хагас жилийн байдлаар Монгол улсын хилээр 1564.8 тн эм, 114.96 тн эмийн түүхий эд, 440.31 тн биологийн идэвхт бүтээгдэхүүн, 395.23тн эмнэлгийн хэрэгсэл, 202.5 тн оношлуур импортын хяналтад хамрагдсан байна.<br>-2024 оны эхний хагас жилийн байдлаар эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр нийт 44 зөрчил нь Дорнод гаалийн газар, СЭГГ, ЧХОУНБГГ, Замын-Үүд гаалийн газарт илэрсэн байна. Зөрчлийг Зөрчлийн тухай хуулийн “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” хуулийн 6.6.2 дахь заалтаар шийдвэрлэсэн бөгөөд зөрчилд холбогдсон 6 аж ахуйн нэгжид 6000 нэгж буюу 6 сая төгрөгийн торгууль, 38 | Улсын хилээр нэвтрүүлж буй бараанд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ. | -Тайлант хугацаанд эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр 3004 кодтой хүн эмнэлэгт хэрэглэх тугнагдсан эм 1989.9тн, 2106 кодтой эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн 4137.53тн, 3002 кодтой вакцин биобэлдмэл 13.62тн, 3822 кодтой урвалж оношлуур 154,721тн, 9018 кодтой эмнэлгийн хэрэгсэл, багаж хэрэгсэл 728.35 тн импортлогдсон байна.<br>-Экспортын хяналтаар 3004 кодтой уламжлалт эм 1.998 тн, 9018 кодтой эмнэлгийн багаж, эмнэлгийн хэрэгсэл 100.25кг, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн 16.75 тн хилээр гарсан байна.<br>-Тайлант хугацаанд Эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр СЭГГ, ЧХОУНБГГ, УБГГ, ЗҮГГ-т 72 зөрчил илэрсэн бөгөөд дээрх зөрчилд 6 ААН, 68 иргэн холбогдож, ЗТХ 6.6.2 дахь заалтын дагуу 2 иргэнд 10 нэгж буюу 10 сая төгрөгийн торгууль ногдуулж, 5 ААН-д 11.21.11 дэх заалтын дагуу 5 мянган нэгжийн торгууль, 66 иргэнд 6600 нэгжийн торгууль ногдуулж барагдуулсан байна. УБГГ-т Кашмия ХХК-ын 5 нэрийн эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн нь тээвэрлэлтийн горим зөрчиж импортлогдсон тул Зөрчлийн тухай жилийн 6 дугаар зүйлийн 6.6.2 дахь заалтаар зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагаа эхлүүлж, зөрчлийг шалгаж байна.<br>-Илэрсэн зөрчлүүдийн ихэнх хувийг зорчигч хувийн хэрэглээнээс илүү хэмжээтэй эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан зөрчил байна. | 2025.01.01<br>2025.06.10 | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | иргэнд 3800 нэгж буюу 3сая 800 мянган төгрөгийн торгууль ногдуулж 100 хувь барагдуулж ажилласан байна. Нийт илэрсэн зөрчлийн 8 зөрчлийг зөрчлийн хэрэг нээж, 36 зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн. | | УБГГ болон ЧХОУНБГГ-т илэрсэн зөрчилтэй холбогдуулан чиглэл хариуцсан байцаагчдыг мэргэжлийн удирлагаар хангаж ажилласан.<br><br>-Хяналт шалгалтын 7 зааврыг боловсруулж, CAIS системийн хяналт шалгалтын заавар цэсэнд оруулж, ГУАБ-д хянуулахаар илгээсэн болно.<br><br>-Тайлант хугацаанд 20 албан бичиг, 50 дотоод зурвас хүлээн авч, 18 албан бичиг 35 дотоод зурвасыг боловсруулж, ирсэн бичгүүдийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.<br><br>-Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын хяналтын удирдлагын систем”-ийг гаалийн автоматжуулсан мэдээллийн системтэй уялдуулах хүрээнд CAIS-ийн “Хорио цээр” цэсэнд орчинд зорчигчийн эмийн бүртгэлийн модулийг нэвтрүүлж, харьяа гаалийн газар хороодод ашиглагдаж байна. Эхний хагас жилийн байдлаар тус цэсэнд 259 зорчигчийн эм, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний бүртгэл бичигдсэн байна.<br><br>УБГГ-т 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр “Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлогч аж ахуйн нэгжүүдэд зориулсан татварын хууль тогтоомжийн шинэчлэл” хэлэлцүүлэгт оролцож, оролцогчдын сонирхсон асуултад хариулж, санал бодлыг нь сонсож, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд орсон гол өөрчлөлтүүдийн талаар мэдээлэл өгсөн.<br><br>-Эхний хагас жилийн зөрчлийг 2025 оны мөн үеийн Эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр 44 харьцуулахад 28 зөрчлөөр өссөн үзүүлэлттэй байна.<br>**Хүрсэн үр дүн:** Эм биобэлдмэлийн хяналтыг хэрэгжүүлэхэд холбогдох хууль тогтоомжийн шинэ зохицуулалтыг чиглэл хүргүүлэх албан бичгээр харьяа гаалийн газар хороодод хүргүүлж, шаардлагатай хууль тогтоомжийн талаарх тодруулгыг хүргүүлснээр зөрчилтэй бараа бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрэхээс урьдчилан сэргийлж, зөрчил илэрсэн тохиолдолд салбарын хуулийн заалтаар арга хэмжээг авч ажилласан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | -"Алсын хараа 2050" урт болон дунд хугацааны, Засгийн газрын 2021-2024 оны хөтөлбөр, Гаалийн байгууллагын стратегийн зорилтод хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналттай холбоотой зорилтын биелэлтийг эм бибэлдмэлийн хяналтын чиглэлээр хэрэгжүүлж ажилласан.<br>-Эм биобэдлмэлийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулахтай холбоотойгоор холбогдох албан тушаалтанд санал хүргүүлсэн.<br>-Магадлан шинжилгээ хийх журамд А/315 өөрчлөлт оруулахтай холбоотойгоор холбогдох албан тушаалтанд 4 санал хүргүүлсэн. | Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналттай холбоотой эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах | -Алсын хараа 2050" урт болон дунд хугацааны, Засгийн газрын 2021-2024 оны хөтөлбөр, Гаалийн байгууллагын стратегийн зорилтод хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналттай холбоотой зорилтын биелэлтийг хэрэгжүүлж ажилласан.<br>-2025 оны 2-р улирлын байдлаар Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт "Мэдээлэл хүргүүлж хамтран ажиллах тухай" 2025 оны 02 сарын 18-ны өдрийн 01/803 тоот албан бичиг, 02 сарын 11 өдрийн №02-1/708 тоот "Чиглэл авах тухай" албан бичгийг боловсруулж, хүргүүлсэн.<br>-Хуулийн давхардал хийдлийн талаарх саналыг Хуулийн хэлтэст 2025 оны 01 сарын 29-ний өдрийн №131 болон Зөрчилтэй тэмцэх газарт 2025 оны 03 сарын 26-ны өдрийн №293 тоот дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>-ЭМЯ-ны Эм, эмнэлгийн хэрэгслийн бодлогын хэлтэст 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 02-1.2/2244 тоот албан бичгээр Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн хийдэл, хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хүргүүлсэн.<br>-ГЕГ-ын хуулийн хэлтсийн дарга, БАУХ-ын дарга, ХЦХ-ийн дарга, УБГГ-ын дарга, ЧХОУНБГГ-ын дарга болон ХБГ-ын ГУАБ, ХЦХ-ийн ГУБ нар ЭЭХХЗГ-ын дарга Н.Эрдэнэбаяр болон газар хэлтсийн дарга нартай 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр уулзалт зохион байгуулж, хяналт шалгалт хийхэд тулгамдаж буй асуудлууд, дээж хүлээлгэж өгөхөд гарч буй хүндрэл, цаг үеийн асуудлаар харилцан ярилцаж, цаашид хэрхэн хамтарч ажиллах талаар ярилцлаа.<br>-Энэ уулзалттай холбоотой газар хороодод илэрч буй зөрчлийг хэрхэн шийдвэрлэх талаар чиглэл хүргүүлэх албан бичгийн төслийг Хуулийн хэлтэст 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 559 тоот дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>**Хүрсэн үр дүн:** Бодлогын зорилтыг хангах хүрээнд Засгийн газрын хөтөлбөр болон бусад тогтоол, шийдвэр, биелэлт, хуулийн хэрэгжилтийг хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлж, албан тушаалын тодорхойлолт, стратеги төлөвлөлтийг шинэчилж, гүйцэтгэлийн үр дүнг сайжруулсан. | 2025.01.01<br>2025.06.10 | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Хорио цээрийн үйл ажиллагааг цахимжуулах А/115 ажлын хэсгийн хүрээнд Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдах барааг шалгах 32 хяналтын хуудсыг цахимжуулахтай холбоотойгоор 9.3.4 кодтой “Эм, биобэлдмэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгсэл импортлох үеийн хяналтын хуудас”-ыг цахимжуулахтай холбоотойгоор хяналт шалгалт хийх зааврын төсөл боловсруулан ажиллаж байна | 1.Нэгжийн эрсдэлийг оновчтой тодорхойлох, эрсдэлийг бууруулах зэрэг асуудлаар тусгайлсан ажлын төлөвлөгөөг гарган, цахим судалгааг ХЦХ-ийн албан хаагчдаас авч нэгтгэнэ. | Нэгжийн эрсдэлийг оновчтой тодорхойлох, эрсдэлийг бууруулах чиглэлээр 26 асуулга бүхий “Google form” судалгааг авч, судалгаанд хамрагдсан дүнгээс үзэхэд: хэлтсийн эрсдэлт хүчин зүйл болох удирдлагын арга барил, хүн хоорондын харилцаатай холбоотой асуудал 57.2 хувийг эзэлж байна. Өрөөний эрүүл ахуйн хүндрэлтэй орчин нь эрсдэлт орчинг үүгэж байгаа тухай хэлтсийн нийт албан хаагчдын 14.3 хувь санал асуулга ирүүлсэн байна.<br>**Хүрсэн үр дүн:** Нэгжийн эрсдэлийг тогтоосноор хэлтсийн эрсдэлт хүчин зүйлүүдийг тодорхой болгож, аливаа ажлыг зөв зохион байгуулалттай, үр дүнтэй, цаг хугацаанд нь гүйцэтгэхэд эерэг нөлөө үзүүлсэн. | 2025.01.01<br>2025.06.10 | 100 хувь |
| 5 | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Удирдах дээд байгууллага болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг цаг хугацаанд нь биелүүлж ажилласан. | Хэлтсийн ажлын мэдээг 7 хоног, сар, жилээр төлөвлөн нэгтэн, тайлагнаж ажиллана. | -ХЦХ-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗУГ-аас өгсөн загварын дагуу төлөвлөн, хэлтсийн даргаар батлуулсан.<br>-7 хоногийн хийсэн ажлын мэдээ болон сар бүрийн ажлын төлөвлөгөөнд санал өгч, биелэлтийг хангаж ажилласан.<br>-Засгийн газрын 1111 сувгаар тайлангийн хугацаанд өргөдөл, гомдол ирээгүй байна.<br>-Хэлтэст ирсэн төрийн байгууллага болон хувийн аж ахуйн нэгжээс ирсэн албан бичгийг бүртгэлжүүлэн, удирдлагын цохолтын дагуу холбогдох ГУБ-д хүргүүлж, бүртгэлжүүлсэн.<br>-Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг импортлоход тавигдах шаардлага” сэдвээр гарын авлага, боршурын төсөл боловсруулж, холбогдох нэгжид хүргүүлсэн.<br>Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдэд зориулсан анхан шатны сургалт болон Хорио цээрийн ГУАБ, ГУБ-д зориулсан гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтанд 7 цаг 30 минутын хичээл боловсруулж заасан. | 2025.01.01<br>2025.06.10 | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Дархан-Уул аймаг дахь ГГ-ын 28 гаалийн улсын байцаагчдад 2025 оны 01 дүгээр сарын 14-ны өдөр Эм, эмнэлгийн хэрэгслийн хуулийн шинэчлэл, шуудан илгээмжийн ачааг нэвтрүүлэхэд анхаарах асуудал сэдвээр цахим сургалтыг GOOGLE MEETING цахим холбоосоор зохион байгуулсан.<br>-Зорчигчийн эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг хилээр хэрхэн нэвтрүүлэх талаар ярилцлага бэлгэж, хянуулан, /2мин REEL/ бичлэг хийлгэсэн.<br>- Харьяа гаалийн газар хороодод 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр “Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэхэд анхаарах асуудал” сэдвээр сургалт зохион байгуулж, хяналт шалгалт хийхэд тулгамдаж буй асуудлууд, зөрчлийг хэрхэн шийдвэрлэх талаар харилцан ярилцаж, шинэ мэдээ мэдээлэл хүргэсэн ач холбогдолтой сургалт зохион байгуулсан.<br>**Хүрсэн үр дүн:** Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласнаар удирдлагыг тухай бүр мэдээ мэдээллээр хангаж, удирдах дээд байгууллагаас өгсөн болон удрдлагын өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлсэн. | | |
| 6 | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлэр | Өвчтэй, чөлөөтэй, тасалсан цаг байхгүй. | Ажлын цаг ашиглалт 100 хувь байна. | Тайлант хугацаанд өвчтэй, чөлөөтэй, тасалсан цаг байхгүй. Цаг ашиглалт 100 хувь. | 2025.01.01 2025.06.10 | 100 хувь |
| **Зорилт 1.Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх** | | | | | | | |
| 7 | Магадлан шинжилгээний үйл ажиллагаанд хяналт тавих | Хэрэгжилт, гүйцэтгэлэр | 2024 оны эхний хагас жилийн байдлаар Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эм шинжлэх лаборатори руу УБГГ-аас 17 нэрийн эмийн дээж шижилгээнд хамруулсан бөгөөд зэрэг сорьц илрээгүй байна. Дээрх 17 нэрийн эм нь фармакопейн болон сертификат анализын шаардлага хангасан байна. Энэ нь өмнөх оны мөн үеийн дээжийнд хамруулсан шинжилгээний тоотой | Лабораторийн шинжилгээнд хяналт тавих | -Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын эм шинжлэх лабораторид 13 нэрийн эм, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг чанар аюулгүй байдлын шинжилгээнд хамруулсан. 3 нэрийн эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний хариу “зэрэг” үзүүлэлттэй гарч 2 нэрийн эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг устгасан.<br>1 нэрийн эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний хариу зэрэг гарсантай холбоотой УБГГ-т зөрчлийн хэрэг үүсгэж, шалтын ажиллагаа үргэлжилж байна.<br>-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын эм шинжлэх лабораторийн тоног төхөөрөмж хүрэлцээгүй, урвалж бодисын хангалтгүй байдлаас нийт импортлогдож байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг лабораторийн шинжилгээнд бүрэн хамруулж чадахгүй байна.<br>Чанар аюулгүй байдлын шинжилгээнд хамруулсан дээжийн тоо нь өмнөх оны мөн үеийнхтэй | 2025.01.01-2025.06.10 | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | харьцуулахад 15 дээжээр буюу 87.5 хувиар буурсан байна. | | харьцулахад 4 дээжээр буюу 23.5 хувиар буурсан бөгөөд "эерэг" үзүүлэлттэй шинжилгээний хариу 3-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.<br>**Хүрсэн үр дүн:** Чанар аюулгүй байдлын шаардлага хангаагүй бараа бүтээгдэхүүн улсын хилээр нэвтрэхээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой юм. | | |
| 8 | Гадаад худалдааг хөнгөвчлөх хүрээнд хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Эм биобэлдмэлийн хяналтад заавал хамрагдах барааны жагсаалтыг БТКУС-ын 8 орны түвшинд гаргаж, гадаад худалдааг хөнгөвчлөхөд дэмжлэг үзүүлсэн.<br>-Эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр өгөгдөл солилцооны модулиар солилцох мэдээлэл боловсруулж, хариуцсан байцаагчид хүргүүлсэн.<br>-Гаалийн эрсдэлийн нэгдсэн удирдлагын журмыг шинэчлэн батлуулахтай холбоотой эрсдэлийн шалгуурыг тодорхой болгох, журамд санал өгч ажилласан. | Хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан дүн шинжилгээ хийж, эрсдэлийн шалгуурыг тодорхой болгоно. | -Эм биобэлдмэлийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан дүн шинжилгээ хийж, эрсдэлийн шалгуурыг тодорхой болгосон.<br>- Эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр хийгдэж байгаа хяналт шалгалтын талаар Монгол телевиз болон Монголын гааль пэйжид 2025 оны 02 сарын 14-ний өдөр Зорчигчийн эмийн асуудлаар богино хэмжээний мэдээлэл хүргүүлсэн.<br>Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй "Ургамал, малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах нь" төслийн хүрээнд хэрэгжүүлж буй "Хилийн хяналт удирдлагын систем"-ийн хөгжүүлэлтийг кодчилол, хөгжүүлэлт, суурилуулахад бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэсэн. Энэ ажил дуусаагүй сүүлийн хагас жилд үргэлжилнэ.<br>**Хүрсэн үр дүн:** Хяналт шалгалтыг оновчтой зохион байгуулах, хяналт шалгалтын хугацааг багасгахад чухал ач холбогдолтой. | 2025.01.01<br>2025.06.10 | 100 хувь |
| 9 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Нийгмийн бодлогын байнгын хорооны дэргэдэх дэд ажлын хэсэгт ажиллаж, эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн дэд ажлын хэсгийн хуралд 4 удаа, байнгын хорооны хуралд 2 удаа, УИХ-ын нэгдсэн чуулганы хуралд 1 удаа оролцсон. | | -ЭЭХХЗГ-ын А/190 тушаалаар батлагдсан Эм, эмнэлгийн хэрэгслийг эрсдлийн зэргээр ангилах, журмын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байгаа бөгөөд ажлын хэсгийн 2 удаагийн хуралд оролцож, өөрт хуваарилагдсан эмнэлгийн хэрэгслийг эрсдлийн зэргээр ангилах ажлыг хийж, журмын төсөлд 1 санал хүргүүлсэн.<br><br>-Гаалийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн дээр шаардлагатай мэдээ, мэдээллийг холбогдох албан тушаалтанд хүргүүлж, зорчигчийн эмийн талаар мэдээлэл өгсөн. | 2025.01.01<br>2025.06.10 | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Эм, эмнэлгийн хэрэгсийн тухай хуулийг 2024 оны 06 сарын 05-ны өдөр УИХ-аар эцэслэн батлагдсан. | | -Ирсэн албан бичгийн 2024 оны архивын материалыг архивын 1 нэгж болгон тогтоосон хугацаанд архивт хүлээлгэн өгсөн.<br><br>-ХАСХОМ-ийг ЗУГ-аас гаргасан хуваарийн дагуу гаргаж, баталгаажуулсан.<br><br>-Гаалийн хорио цээрийн байцаагчдад гаалийн хэргийн мэдлэг олгох сургалтад 2025 оны 01 сарын 20-ны өдрөөс 2 долоо хоногийн сургалтад хамрагдсан.<br><br>-Дархан-Уул гаалийн газрын 25 ГУБ хамруулан Эм, эмнэлгийн хэрэгслийг хянаж шалгахад анхаарах асуудал сэдвээр GOOGLE MEETING холбоосоор мэдээлэл өгсөн.<br>-2025 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн байгууллага болон иргэд, аж ахуй нэгжээс ирсэн 168 бичгийг бүртгэлжүүлж, холбогдох албан тушаалтанд хүргэж ажилласан.<br>-Хорио цээрийн ГУБ-д зориулсан 2 долоо хоногийн сургалт болон эхний хагас жилд зохион байгуулагдсан мэдээллийн цагт бүрэн хамрагдсан.<br>-Гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох сургалтад Эм биобэлдмэлийн хяналтад хэрэгжүүлж ажилладаг хууль эрх зүй, анхаарах асуудал болон Эм эмнэлгийн хэрэгслийн бүртгэлийн асуудлын талаар 1 цаг 30 минутын хичээл бэлтгэж, 2 удаагийн хичээл зааж, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн бэлтгэх сургалтад 2 удаагийн хичээл зааж, оролцогчдод Эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр анхан шатны мэдлэг олгосон.<br>**Хүрсэн үр дүн:** Дээрх үйл ажиллагааг зохион байгуулснаар хууль тогтоомжийг дагаж гарах журам боловсронгуй болоход ахиц гарах, байцаагчдад шаардлагатай мэдээ мэдээллийг хүргэснээр хяналт шалгалтыг хууль тогтоомжийн дагуу түргэн шуурхай хийж гүйцэтгэхэд эерэг нөлөө үзүүлсэн. | | |
| **Зорилт 3. Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 10 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, | Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтэст “Мансууруулах эм, | Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын | -УБГГ дээр 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр “Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлогч аж ахуйн нэгжүүдэд зориулсан татварын хууль тогтоомжийн шинэчлэл” хэлэлцүүлэгт оролцож, 50 аж ахуйн | 2025.01.01<br>2025.06.10 | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эрх зүйн актын хэрэгжилт | эрх зүйн актын хэрэгжилт | сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай" хуулийн төсөлд №29 тоот дотоод зурвасаар 2 санал хүргүүлсэн.<br>-Гаалийн тухай хууль шинэчлэгдэн батлагдахтай холбоотойгоор тус хуулийн 227-р зүйлд /зорчигчийн хувийн хэрэглээний эмийн тухай заалт/ 2 санал хүргүүлэн ажилласан.<br>- ЭЗХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 03 сарын 11-ний өдрийн А/44 тушаалаар батлагдсан Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан эрүүл мэндийн зарим хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, үзэл баримтлал боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байна. | хяналттай холбоотой эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах | нэгжийн төлөөллийн асуултад хариулж өгч, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд орсон гол өөрчлөлтүүдийн талаар мэдээлэл өгсөн.<br>-Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Зөрчлийн тухай хуулинд өөрчлөлт оруулах тухай саналыг ЭМЯ-ны эмийн бодлогийн хэлтэст хүргүүлж ажилласан.<br>**Хүрэх үр дүн**: Хууль тогтоомжийн давхардал, хийдэл арилж, хуулийн заалтуудын хоорондох үл нийцэл арилснаар хяналт шалгалт хийхэд тулгамдаж буй асуудлууд багасах сайн нөлөөг үзүүлсэн. | | |

**Нэг. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхлэсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Монгол бичгийн мэдлэг чадвараа бие даан сайжруулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Монгол бичгээр унших, бичих чадвар дунд | Монгол бичгээр унших, бичих чадвар сайжруулах | Монгол бичгийн унших, бичих чадварыг сайжруулах зорилгоор 7 хоногт 1 удаа 45 минутын хичээлд нийт 15 удаагийн онлайн хичээлд хамрагдсан. | 2025.01.01<br>2025.06.10 | 100 хувь |
| 2 | Эм биобэлдмэлийн хяналт болон гаалийн хяналт шалгалттай холбоотой шинээр | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Шинээр гарсан эрх зүйн актуудыг тухай бүр нь унших | Хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлж, өдөр тутмын үйл | ЭМС-ын № А/209 тоот тушаалаар "Эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнд мэдүүлэг олгох | 2025.01.01<br>2025.06.10 | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гарсан хууль тогтоомж, бусад эрх зүйн актуудыг тухай бүр судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | | судлан хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн. | ажиллагаандаа мөрдөж ажилласан байна. | журам" батлагдсаныг судалж, чиглэл хариуцсан ГУБ-д хүргүүлсэн. Зөрчлийн тухай хуульд орсон өөрчлөлттэй холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд юуг анхаарах талаар чиглэл хариуцсан байцаагч нарт чиглэл хүргүүлсэн. | | |
| 3 | Англи хэлний мэдлэгийн түвшинг ахиулах | Сургалтын тоо | Англи хэлний дунд шатны мэдлэгтэй. | Бие даан англи хэлний мэдлэгээ сайжруулна. | TALK TALK English англи хэлний сургалтын төвд түвшингээ тогтоолгож, IELTS Batja пэйжийн онлайн сургалтад хамрагдсан. | 2025.01.01 2025.06.10 | 100 хувь |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЭМ БИОБЭЛДМЭЛИЙН ХЯНАЛТ ХАРИУЦСАН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ........................................ /М.ПҮРЭВСҮРЭН/ 2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10 ӨДӨР

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ М.ПҮРЭВСҮРЭНГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Хорио цээрийн хэлтэс

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх** | | | | | |
| 1 | Магадлан шинжилгээний үйл ажиллагаанд хяналт тавих | 59 | 8 | 67 | |
| 2 | Гадаад худалдааг хөнгөвчлөх хүрээнд хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлэх | 57 | 9 | 66 | |
| 3 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | 58 | 8 | 66 | |
| **Зорилт 2. Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах** | | | | | |
| 4 | Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын хэрэгжилт | 57 | 9 | 66 | |
| 5 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | 59 | 8 | 67 | |
| 6 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | 59 | 8 | 67 | |
| 7 | Үүрэг даалгаврын биелэлт | 58 | 8 | 66 | |
| 8 | Ажлын цаг ашиглалт | 59 | 8 | 67 | |
| **Зорилт 3. Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх** | | | | | |
| 9 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | 58 | 9 | 67 | |
| **Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт** | | | | | |
| 10 | Хэлтэст ирсэн албан бичгийн бүртгэл хөтлөх, удирдлагын цохолтын дагуу байцаагчдад хүргэх, мэдээллээр хангах | 57 | 7 | 64 | |
| 11 | Гаалийн улсын байцаагчдын сул орон тоо зарласантай холбоотойгоор шалгалтад тэнцсэн гаалийн улсын байцаагчдад хичээл заах | 59 | 8 | 67 | |
| 12 | Даргын өгсөн үүрэг даалгавар болон албан бичгээр ирсэн агуулгын дагуу сургалт, семинар хэлэлцүүлэгт оролцох, үүрэг даалгаварыг биелүүлэх | 57 | 9 | 66 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 13 | ЭЭХХЗГ-ын А/190 тушаалаар батлагдсан Эм, эмнэлгийн хэрэгслийг эрсдлийн зэргээр ангилах, журмын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллах | 57.9 | 8 | 65.9 | |
| **Дундаж оноо:** | | | | 66.3 | |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Монгол бичгийн мэдлэг чадвараа бие даан сайжруулах | 100 | 13 | |
| 2 | Эм биобэлдмэлийн хяналт болон гаалийн хяналт шалгалттай холбоотой шинээр гарсан хууль тогтоомж, бусад эрх зүйн актуудыг тухай бүр судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | 100 | 15 | |
| 3 | Англи хэлний мэдлэгийн түвшинг ахиулах | 100 | 12 | |
| **Дундаж оноо:** | | | 13.3 | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1 | Хандлага, ёс зүй | 6 | |
| 2 | Дүн шинжилгээ хийх | 6 | |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 6 | |
| 4 | Хариуцлагатай байдал | 6 | |
| 5 | Ажлын цаг ашиглалт | 6 | |
| **Дундаж оноо:** | | **6** | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1 | Хандлага, ёс зүй | 8 |
| 2 | Багаар ажиллах | 8 |
| 3 | Харилцаа | 8 |
| **Дундаж оноо:** | | **8** |

## 5. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)* | 66.3 |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 13.3 |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | 6 |
| 4 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | 8 |
| 5 | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | **93.6** |

***Үнэлгээ өгсөн:***

***Нэгжийн дарга:***
Хорио цээрийн хэлтсийн дарга ............................ (Г.Батмөнх)

2025.06.10 ........................(огноо)

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***
Гаалийн улсын байцаагч ..................................(М.Пүрэвсүрэн)

2025.06.10 ........................(огноо)

***Үнэлгээг хянасан :***

***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***
Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ................................ (Г.Энхтайван)

2025.06.15 ........................ *(огноо)*

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***
Хүний нөөцийн хэлтсийн
гаалийн улсын ахлах байцаагч ..............................(Ө.Тэгшээ)

2025.06.25
..................... *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:***

***Төсвийн шууд захирагч:***
Гаалийн ерөнхий газрын дарга .................................. (Р.Отгонжаргал)

2025.06.25
...................................*(огноо)*